



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар

А/01

Амардалай

Цалин нэмэгдлийг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох" 2019 оны 472 дугаар тогтоолын 2, 5, 7, 8, 10, 11 дүгээр хавсралт, Засгийн газрын "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай" 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.6 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох" тухай журмын 2 дугаар зүйлийн 2.10 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29.2, УИХ-ын байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарын цалинг 1 дүгээр, ЗДТГ-ын даргын цалинг 2 дугаар, ЕБС-ийн захирлын цалинг 3 дугаар, ЭМТ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчийн цалинг 4 дүгээр, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн цалинг 5 дугаар, Соёлын төвийн даргын цалинг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр: Батлагдсан цалингийн санд багтаан цалинг сар бүр бодож олгохыг нягтлан бодогч /Д.Долгорсүрэн, Л.Амаржаргал, Б.Энхманлай/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

4880100010